



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/16/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [Saranchimegtst@audit.gov.mn](mailto:Saranchimegtst@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
<b>3.4.1 Мөнгөн хөрөнгө</b> .....	12
<b>3.5.2 Авлага</b> .....	12
<b>3.5.3 Урьдчилгаа</b> .....	13
<b>3.5.4 Бараа материал</b> .....	13
<b>3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө</b> .....	14
<b>3.5.6 Үндсэн хөрөнгө</b> .....	14
<b>3.5.7 Өр төлбөр</b> .....	15
<b>3.5.10 Засгийн газрын хувь оролцоо</b> .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	20
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	20
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	20
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	20
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	20
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	20
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	21
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	21
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	21
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	22
<b>5.3 Зөвлөмж</b> .....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	25

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/236  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 15 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 7 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан.

2023 онд Төвийн худаг, Малчны хорооны худгуудыг цахимжуулан, Дэнжийн ар, Хөдөлмөр зусланд шинээр 2 худгийг ОНХС-ийн хөрөнгөөр гаргаж, цахим төхөөрөмжийг суурилуулснаар иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 298,677.3 мянган төгрөгөөр буюу 24,3%-аар давуулан биелүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		794,425.4	1,296,972.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	213,999.7	634,127.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	389,831.2	425,707.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	190,594.4	237,138.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,514,426.6	3,509,223.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,514,426.6	3,509,223.3
39200	Биет хөрөнгө		2,325,792.1	3,315,708.0
39300	Биет бус хөрөнгө	13	188,634.5	193,515.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,308,851.9	4,806,196.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,460.0	11,473.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,460.0	11,473.8
41300	Өглөг	17а, 17б	9,460.0	11,473.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,299,391.9	4,794,722.3
51	Засгийн газрын хувь оролцоо		3,299,391.9	4,794,722.3
51200	Хуримтлагдсан үр дүн		2,116,642.5	3,612,065.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		711,405.9	711,312.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,308,851.9	4,806,196.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,312,772.0	3,618,575.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		816,726.0	1,219,317.3
110	Орлогын албан татвар		607,132.2	959,814.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		634,274.5	988,814.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-27,142.3	-29,000.0
113	Хөрөнгийн албан татвар		64,389.8	94,258.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		145,204.0	165,244.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	823,237.7	1,224,535.3
120	Нийтлэг татварын бус орлого		823,237.7	1,224,535.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		672,808.2	1,174,722.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,697,868.8	2,124,350.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,642,316.7	1,895,244.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,573,233.7	1,872,149.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		368,402.5	545,890.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		46,231.3	69,873.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		518,907.3	606,221.2
2104	Хангамж, бараа материалын зардал		37,128.8	41,869.1
2105	Нормативт зардал		188,673.0	177,512.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,559.7	7,335.9
2107	Томилолт, зочны зардал		2,443.0	2,944.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		87,817.5	8,269.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		315,070.6	412,234.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		69,083.0	23,095.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		55,552.1	229,105.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		614,903.2	1,494,224.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		7,236,342.7	804.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-6,621,439.5	1,493,420.6

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,001,952.80	3,011,038.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	816,726.0	1,219,317.3
110	Орлогын албан татвар	607,132.2	959,814.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	634,274.5	988,814.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,142.3	-29,000.0
113	Хөрөнгийн албан татвар	64,389.8	94,258.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	145,204.0	165,244.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,983.2	32,639.6
1181	Газрын төлбөр	106,264.2	106,178.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,956.6	26,426.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	512,418.50	616,998.2
120	Нийтлэг татварын бус орлого	512,418.50	616,998.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	672,808.20	1,174,722.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,503,636.10	1,540,352.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,503,636.10	1,540,352.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,420,796.3	1,517,257.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,402.5	544,274.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,231.3	69,330.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	522,153.1	69,273.3
2104	Хангамж, бараа материалын зардал	33,038.0	42,781.1
2105	Нормативт зардал	212,338.8	198,531.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,421.7	2,297.4
2107	Томилолт, зочны зардал	2,443.0	2,944.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	88,245.5	8,285.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,522.5	579,540.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,839.80	23,095.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-	498,316.6	1,470,685.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	505,547.4	934,753.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	505,547.4	934,753.9
2200	Дотоод эх үүсвэрээр	505,547.4	934,753.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-505,547.4	-934,753.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-116,099.6	-115,804.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	116,099.6	115,804.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-123,330.3	420,127.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	337,330.1	213,999.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	213,999.7	634,127.2

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,078,960.8	10,078,960.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-157,974.5	-157,974.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,920,986.3	9,920,986.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-154.8	-154.8
9	Тайлант үеийн үр дүн	-6,621,439.5	-6,621,439.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,299,391.9	3,299,391.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,299,391.9	3,299,391.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,301,394.8	3,301,394.8
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,794,722.3	4,794,722.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,630,548.9</b>	<b>2,319,941.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,361,153.5</b>	<b>1,298,887.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,342,404.5</b>	<b>1,281,138.4</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>516,558.6</b>	<b>501,457.5</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,474.8</b>	<b>64,367.1</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>635,839.3</b>	<b>610,602.0</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,190.0</b>	<b>39,315.7</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,000.0</b>	<b>996.9</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,800.0</b>	<b>8,293.4</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,713.0</b>	<b>2,624.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>11,628.0</b>	<b>10,067.1</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,200.8</b>	<b>43,414.6</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,749.0</b>	<b>17,749.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,749.0</b>	<b>17,749.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,117,145.4</b>	<b>905,249.9</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР</b>	<b>152,250.0</b>	<b>115,804.3</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,630,548.9</b>	<b>2,314,018.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>706,851.8</b>	<b>689,156.5</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,655,363.6</b>	<b>1,525,721.1</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>248,333.5</b>	<b>99,141.2</b>
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>20,000.0</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>262,746.7</b>	<b>203,133.0</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>203,133.0</b>	<b>197,210.3</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>32</b>	<b>32</b>
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	5	5
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>32</b>	<b>32</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	13
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>156,241.9</b>	<b>58,662.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,241.9	58,662.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,275.9	51,328.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	39,706.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,963.3
2104	Хангамж, бараа материалын зардал	9,770.8	820.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,048.7	1,494.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,456.5	4,345.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,966.0	7,333.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,260.0	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,706.0	7,333.3
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>147,602.4</b>	<b>58,662.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147,602.4	58,662.0
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(8,639.5)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,639.5	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

2023 онд Төвийн худаг, Малчны хорооны худгуудыг цахимжуулж, Дэнжийн ар, Хөдөлмөр зусланд шинээр 2 худгийг ОНХС-ийн хөрөнгөөр гаргаж, цахим төхөөрөмжийг суурилуулснаар иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар, цаг хугацааны хувьд ахиц дэвшил гарсан.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 14 зорилт, 109 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж, 83,7 хувиар хэрэгжүүлсэн байна. Аймгийн Засаг дарга болон Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2023 онд нийт 138 хэрэгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласнаас 84 зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 25 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 14 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 15 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 87,7 % хувьтай дүгнэгдсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын дэргэдэх дотоод хяналтыг ЗДТГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/335 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийх комиссыг томилж, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг 5 ажил төлөвлөснөөс 3 ажлыг хэрэгжүүлсэн. Шалгалт хийгдсэн байгууллагуудад хяналт шалгалтын үр дүнг танилцуулан зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Дотоод хяналтыг эрсдэлтэй асуудал руу чиглүүлэн төлөвлөх болон дотоод хяналтаар илэрсэн асуудлыг давтан шалгаж зөрчлийг бууруулсан талаар тайлагнах ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн А/251 тоот захирамжаар баталж санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Төв аймгийн ТЭЗ-ийн бөгөөд Засаг даргын 2021 онд “Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан бөгөөд сумдын санхүүгийн албанд файлаар 2024 оны 01 дүгээр сард ирсэн тул 2023 онд мөрдөж ажиллаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сум нь Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,497,344.2 мянган төгрөгөөр буюу 45,3 хувиар өссөн байна. Энэ аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын барилгын их засвар хийгдсэн, орон нутгийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	213,999.7	634,127.2	420,127.5
Авлага	389,831.2	425,707.4	35,876.2
Бараа материал	190,594.4	237,138.2	46,543.8
Үндсэн хөрөнгө	2,514,426.6	3,509,223.3	994,796.8
Нийт хөрөнгө	3,308,851.9	4,806,196.2	1,497,344.2
Өр төлбөр	9,460.0	11,473.8	2,013.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,299,391.9	4,794,722.3	1,495,330.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,308,851.9	4,806,196.2	1,497,344.2

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 634,127.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 420,127.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын данс 430,307.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 425,707.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,876.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сан 28,875.8 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн авлага 5,753.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 237,138.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 46,543.8 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ 25,335.7 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 21,208.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,509,223.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 994,796.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЗДТГ 984,124.8 мянган төгрөгөөр, Эмийн

эргэлтийн сан 8,023.8 мянган төгрөгөөр, ИТХ 2,648.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Өглөг дансны үлдэгдэл 11,473.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,013.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хогийн цэгийг хашаажуулах ажлын урьдчилгаа олгоод ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй 8,960.0 мянган төгрөг, Эргэлтийн эмийн сан 1,763.8 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргээх барьцаа санд байгууллагад өгөх 750.0 мянган төгрөгийг тус тус тайлагнасан холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 4,794,722.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,495,330.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 1,493,420.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 634,127.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 129,660.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	213,999.7	634,127.2	420,127.5
Төгрөг	213,999.7	634,127.2	420,127.5
Төрийн сангийн харилцах	208,991.5	633,625.9	424,634.4
Арилжааны банк дахь харилцах	5,008.2	501.3	(4,507.0)
<b>ДҮН</b>	<b>213,999.7</b>	<b>634,127.2</b>	<b>420,127.5</b>

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 633,625.9 мянган төгрөгийн 68,4 хувь буюу 433,390.6 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын, 24,2 хувь буюу 153,541.8 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 6,9 хувь буюу 43,668.5 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн, 0,5 хувь буюу 3,025.0 мянган төгрөгийг БНСБС-ийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 501.3 мянган төгрөгийн 493.3 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн, 8.0 мянган төгрөгийг Эко төв Жаргалант ОНААТҮГ-ийн үлдэгдэл эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 634,127.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 420,127.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын данс 430,307.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант онд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл нь 298,058.5 мянган төгрөгөөр давж биелсэн орлого болон төсөвт байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 62,266.0 мянган төгрөг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт

- ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 19,426.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зөрчилд зөвлөмж өгөв.
- ЗДТГ-ын харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтын цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 26,006.6 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд албан шаардлага бичив.
- Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг ЗДТГ 11,337.1 мянган төгрөг, ИТХ 2,525.3 мянган төгрөг тус тус илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Э-тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд ЗДТГ 48,515.2 мянган төгрөг, ИТХ 4,792.9 мянган төгрөгийн төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг хийгдээгүй байсныг аудитын явцад хийж залруулав.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 425,707.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,876.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Дансны авлага	4,368.7	10,122.4	5,753.7
Байгууллагаас авах авлага	49,335.2	50,582.0	1,246.8
Хувь хүмүүсээс авах авлага	336,127.3	365,003.0	28,875.7
<b>ДҮН</b>	<b>389,831.2</b>	<b>425,707.4</b>	<b>35,876.2</b>

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 425,707.4 мянган төгрөгийн 85,7 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 11,9 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Бусад авлагын 415,585.0 мянган төгрөгийн 87,8 хувь буюу 365,003.0 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 12,2 хувь буюу 50,582.0 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 50,582.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 365,003.0 мянган төгрөг, ЭЭС-ийн ЭМД-аас авах авлага 10,122.4 мянган төгрөг нийт 425,707.4 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна.

Нийт авлага өмнөх оноос 35,876.2 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сан 28,875.8 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн авлага 5,753.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

**Аудитын илрүүлэлт**

1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг авлагын тодруулга тайланд 5 жилээс дээших 365,003.1 мянган төгрөгийн авлагыг насжилтаар зөв ангилаагүй зөрчлийг аудитын явцад залруулав.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл Монгол банкны мэдээллийн санд оруулсан зээлийн авлагын үлдэгдэл 7,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

**3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 237,138.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 46,543.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>108,645.2</b>	<b>127,863.6</b>	<b>19,218.4</b>
Тусгай зориулалттай материал	6,653.6	6,523.9	(129.7)
Эм боох материал	101,991.6	121,339.7	19,348.1
<b>Хангамжийн материал</b>	<b>81,949.3</b>	<b>109,274.7</b>	<b>27,325.4</b>
Бичиг хэргийн материал	572.6	1259.788	687.2
Аж ахуйн материал	2015.2	1937.3	(77.9)
Сэлбэг хэрэгсэл	24236.5	38336.5	14,100.0
Түлш, шатах тослох материал	3392	7772.8	4,380.8
Барилгын засварын материал	857.4	5405.1	4,547.7
Бусад хангамжийн материал	50875.6	54563.169	3,687.6
<b>ДҮН</b>	<b>190,594.4</b>	<b>237,138.2</b>	<b>46,543.8</b>

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 237,138.2 мянган төгрөгийн 46,3 хувийг ЗДТГ, 52,8 хувийг Эмийн эргэлтийн сан, 0,95 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 237,138.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 46,543.8 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ 25,335.7 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 21,208.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансанд оны эхний үлдэгдэл 190,594.4 мянган төгрөг байсан бол 285,148.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 32,341.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 310,958.8 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэн ба 270,946.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 237,138.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ нь бусад хангамжийн материалын дансанд 2 асар майхан бүртгэсэн, сэлбэг хэрэгсэл дансанд квош, тракторын сэлбэг, цагдаагийн машины сэлбэгийг бөөн дүнгээр бүртгэж зарлагдсан 17,630.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.
2. ЗДТГ-ын жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлээс зөрүүтэй зөрчилд тооллогын комиссын үүрэг хариуцлагыг сайжруулах, тооцоо бодолтын үр дүнг удирдлага танилцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,509,223.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 994,796.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,325,792.2</b>	<b>3,315,708.0</b>	<b>989,915.8</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,041,956.4	1,811,116.3	769,159.9
Авто-тээврийн хэрэгсэл	246,400.2	259,232.8	12,832.6
Машин тоног төхөөрөмж	154,080.9	170,772.1	16,691.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	56,440.6	94,565.5	38,124.9
Бусад үндсэн хөрөнгө	826,914.1	980,021.3	153,107.2
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>188,634.5</b>	<b>193,515.3</b>	<b>4,880.8</b>
Программ хангамж	43.5	3,014.5	2,971.0
Бусад биет бус хөрөнгө	188,591.0	190,500.8	1,909.8
<b>ДҮН</b>	<b>2,514,426.7</b>	<b>3,509,223.3</b>	<b>994,796.6</b>

*Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 3,497,909.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,1 хувь буюу 3,080.3 мянган төгрөгийг ИТХ, 0,2 хувь буюу 8,233.1 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,509,223.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 994,796.6 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ 984,124.8 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сан 8,023.8 мянган төгрөгөөр, ИТХ 2,648.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө тайлант онд 226,797.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,065,391.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж 10,505.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан, 2,849.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ нь байгууллагын санхүүгийн тайлан дахь бүртгэлээс 22 газрын мэдээлэл бүртгэлд дутуу 967,091.2 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд зөвлөмж өгсөн.
2. ЗДТГ-т элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1021 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг хөрөнгийг хугацааг уртасгах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг талаар зөвлөмж өгсөн.
3. ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоходоо ашиглах хугацааг буруу оруулсан хөрөнгийн үлдэх өртгийг хасах дүнгээр илэрхийлсэн, газарт элэгдэл байгуулсан зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 11,473.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,013.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	9,460.0	11,473.8	2,013.8
<b>ДҮН</b>	<b>9,460.0</b>	<b>11,473.8</b>	<b>2,013.8</b>

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдлийн 78,1 хувь буюу 8,960.0 мянган төгрөгийг сумын ОНХС, 6,5 хувь буюу 750.0 мянган төгрөгийг БНСБС, 15,4 хувь буюу 1,763.8 мянган төгрөгийн Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 9,460.0 мянган төгрөг болж, 500.0 мянган төгрөгөөр оны эхнээс өссөн нь БНСБС-д хөрөнгө төвлөрүүлсэнтэй холбоотой өссөн байна. Энэ нь ОНХС-аар хэрэгжүүлсэн хогийн цэгийн хашаа хийх 8,960.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн алдаа зөрчилгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,792,719.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,493,327.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	471,343.5	471,343.5	-
Засгийн газрын сан/Орон нутгийн сан			
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,116,642.5</b>	<b>3,610,063.1</b>	<b>1,493,420.6</b>
Өмнөх үеийн үр дүн	8,738,082.0	2,116,642.5	(6,621,439.5)
Тайлант үеийн үр дүн	(6,621,439.5)	1,493,420.6	8,114,860.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	711,405.9	711,312.9	(93.0)
<b>ДҮН</b>	<b>3,299,391.9</b>	<b>4,792,719.4</b>	<b>1,493,327.5</b>

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 4,792,719.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,493,327.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 1,493,420.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,473,607.2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,473,607.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 211,525.0 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 тоот тогтоолоор нийт зардал 2,262,082.2 мянган төгрөгөөр, үүнээс урсгал зардлыг 1,482,637.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 779,444.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсөв захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй ба урсгал зардлыг бууруулснаас шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 365,383.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2,630,548.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Энэ нь урсгал зардлыг 228,059.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 140,407.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт дүнгээр 365,383.2 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 1,228,459.5 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 426,904.1 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 3,083.5 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 706,851.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээр 93,000.0 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээгээр 20,000.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 152,250.0 мянган төгрөгийн нийт 2,630,548.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,098,817.0 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 426,904.1 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 689,156.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 99,141.2 мянган төгрөгийн нийт 2,314,018.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 316,530.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 152,250.0 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 99,141.2 мянган төгрөг бүрдүүлж 53,108.8 мянган төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна. Нийгмийн хариуцлагын гэрээний орлого 20,000.0 мянган төгрөг бүрдүүлэх эх үүсвэр бүрдээгүй байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 1,228,459.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 1,527,136.8 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 298,677.3 мянган төгрөгөөр буюу 24,3%-иар давуулан биелүүлсэн байна. Энэ нь цалингийн ашиг 174,509.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогын албан татвар 144,276.5 мянган төгрөг, газрын дуудлага худалдаа 222,745.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.

Тасарсан орлогыг нэр төрлөөр нь задалбал Суутган-2 татвар 1,717.2 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 70,504.9 мянган төгрөг, галт зэвсэгийн албан татвар 210.0 мянган төгрөг, газрын төлбөр 20,919.5 мянган төгрөг, ойн төлбөр 2,433.3 мянган төгрөг,

түрээсийн төлбөр 250.2 мянган төгрөг, нэр зааж ангилагдаагүй орлого 205,055.9 мянган төгрөгөөр нийт 7 төрлийн орлого 301,090.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төв аймгийн Жаргалант сумын 2023 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 2,630,548.9 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 2,319,941.6 мянган төгрөг буюу 310,607.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 88,2 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 15,208.8 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 25,237.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 3,874.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 3.1 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардал 2,089.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 1,560.9 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал 13,786.2 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 1,000.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 211,895.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 36,445.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

## **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа /70105/	103,752.2	98,959.3	4,792.9	95.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/	898,412.2	849,896.9	48,515.3	94.6
3	71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	61,949.3	61,949.3	-	100.0
4	71801-Сургуулийн өмнөх боловсрол	92,701.6	86,743.6	5,958.0	93.6
5	71802-Ерөнхий боловсролын сургууль	303,677.2	303,677.2	-	100.0
6	71702-Соёлын үйлчилгээ	97,954.6	94,954.6	3,000.0	96.9
7	70106-Хоршоо хөгжүүлэх сан	152,250.0	115,804.2	36,445.8	76.1
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	919,851.8	707,956.3	211,895.5	77.0
	Нийт дүн	<b>2,630,548.9</b>	<b>2,319,941.4</b>	<b>310,607.5</b>	<b>88.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 58,661.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, цалин нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал 44,669.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардал 820.0 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардалд 4,345.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,494.0 мянган төгрөг, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 7,333.3 мянган төгрөгийг аймаг болон орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

## **Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан	
1.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн						
1.1					103,752.2	98,959.3	
ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	1.1.1	Сумын ИТХ-ын төлөөлөгч, зөв-лөл, хороодын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах	2023.01.01-2023.12-31	Төлөөлөгөөний хэрэгжилтээр	1.1.1 СИТХ-ын хуралдаан 2023 онд дунджаар 90,0 хувийн ирцтэй хуралдлаа. СИТХ-ын хуралдаанаар 2023 онд нийт 38 асуудал хэлэлцэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 35 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. СИТХ-ын хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 92,1 хувь, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 72,2 хувь байгаа тул сумын ИТХ, Зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаа 81,3 хувь "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн.	84,477.2	81,190.4
	1.1.2	Багийн ИНХ-ын үйл ажиллагаа	2023.01.01-2023.12-31	БИНХ-ын бэлтгэл ажлыг хангаж, ИНХ-аас гаргасан тогтоол шийдвэрийг иргэдэд сурталчилах сургалт зохион байгуулах хуралдааны ирцыг бүрэн хангах. БИНХТ нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана. БИНХ-ын ажил хэрэгч байдал сайжирна.	1.1.2 Багуудын ИНХ-ыг 2023 онд баг тус бүр 2 удаа зохион байгуулж, багийн өдөрлөг 1 удаа зохион байгуулагдсан байна.	11,425.0	10,866.5
1.2	Гэмт хэргээс урьдчилан						
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1.2.1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. Сургалт сурталчилгааны хөтөлбөр батлуулж хэрэгжилтийг зохион байгуулна	2023.01.01-2023.12-31	Сумын ГХУСА33-ийг төлөвлөгөөтэй ажиллуулж, хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг нь тооцож ажиллах сумын дэд зөвлөлдүүдийн ажилд мэргэжил арга зүйг удирдлагаар хангаж ГХУС талаар сургалт сурталчилгаа хийж хуралдаан тэмцээн зохион байгуулж суманд гарч байгаа гэмт хэрэг буурсан байна.	1.2.1 Сумын ИТХ-ын хуралдаанаар СГХУСА33-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. СГХУСА33-ийн хурлыг 3 удаа хуралдаж 2022 онд хийсэн ажлын тайлан, 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөө, хорт ургамал устгах тухай, ажлыг дүгнэх тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон төсвөөс 1.0 сая төгрөгийг төсөвт суулгаж өгсөн бөгөөд ААН, иргэдийн эзэмшлийн 800 га талбайд ургамлыг устгах арга хэмжээ авсан. 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг ном хэлбэрт оруулан 200 ширхэгийг хэвлэж малчид, иргэд, ААНБ-уудад тараан өгч сурталчилан ажиллав.	7,850.0	6,902.4
	Сумын Засаг дарга					898,412.2	849,896.9
2	2.1	Орон нутгийн гүйцэтгэх					
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2.1.1	Гүйцэтгэх засаглалын удирдлага, тэдгээрийн ажлын алба	2023.01.01-2023.12-31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж хэрэгжилт-ийг хангах. Иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэх, ТАХ-чид хариуцсан салбар нэгжийнхээ үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг чадвартай болох.	Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө 27 арга хэмжээ батлагдаж 91,1%-тай хэрэгжсэн.	655,043.7	629,895.7
	2.1.2	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	2023.01.01-2023.12-31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 9 арга хэмжээ төлөвлөж 7 хэрэгжсэн 77,7 % байна	24,531.0	18,463.1
	2.1.3	Баг хорооны үйл ажиллагааны зардал	2023.01.01-2023.12-31	Багийн иргэдэд төр засгийн бодлогыг сурталчилж төрийн үйлчилгээг цаг алдалгүй анхан шатны нэгжид богино хугацаанд чанартай хурдан шуурхай хүргэж ажилладаг	Сумын 4 баг тус бүр шинээр гарсан болон нийтээр дагаж мөрдөж буй хууль дүрэм, журмыг хэрэгжилтийг хангуулан ажиллаж иргэдэд 8 төрлийн үйл ажиллагааг хүндрэл ирэгдэлгүй түргэн шуурхай хүргэж хэрэгжилт 85,2 % тай байна	193,837.5	178,907.4
	2.1.4	Орон нутгийн нөөц сан	2023.01.01-2023.12-31	ОН-ын нөөц хөрөнгө нь цаг агаарын хүндрэлтэй нөхцөл гамшиг ослоос хамгаалах урьдчилан сэргийлэхэд оршино	Орон нутгийн нөөц хөрөнгийн зардалын санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу гүйцэтгэж өвөгжилтийн бэлтгэл ажил хангахад зориулан автомашин засварлах, шатахууны зардал зарцуулсан.	5,000.0	4,999.3
	2.1.5	Хур хог хаягдал, Орчны бохирдлыг устгах	2023.01.01-2023.12-31	Нийтийн эзэмшлийн хог хаягдлыг цэвэрлэх хөлийн цэгийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлыг зохион байгуулах	Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн зэрэглэлийг сайжруулж хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хөлийн цэгт 380 хүчдэлтэй тог татсан.	20,000.0	17,631.4
3	1	71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	2023.01.01-2023.12-31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан.	61,949.3	61,949.3
4	1	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12-31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан.	92,701.6	86,743.6
5	1	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01-2023.12-31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан.	303,677.2	303,677.2
6	1	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12-31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан.	97,954.6	94,954.6
7	1	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12-31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх	2022 оны 1 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. 2023 оны 10 сард дахин өөрчлөгдсөн. Хэрэгжилт 100%	152,250.0	115,804.2
			2023.01.01-2023.12-31	Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл 115.0 сая төгрөгийн олгож тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн байна	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж 1 хоршоо, 6 иргэн тэнцэж 115.0 сая төгрөгийн олгож тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн байна		
8	1	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12-31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 3 төсөл, шинээр хэрэгжих 23 төслийг 919,851.8 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 13 төсөл арга хэмжээ. 13 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 50.0 хувьтай.	919,851.8	707,956.3

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд хөрөнгө оруулалтын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр дутуу бүрдсэн нь нөлөөлсөн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 61 бараа, ажил үйлчилгээг худалдаг авахаар 2,024,317.1 мянган төгрөгөөр баталсан ба үүнээс 13 бараа, ажил үйлчилгээ оролцогч байгууллага байхгүйн улмаас хийгдээгүй байна. Бусад 48 бараа, ажил үйлчилгээг 1,793,134.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Төсөвт байгууллагуудын 101,811.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтаар зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүйн улмаас шууд худалдан авалт хийсэн байна. ЕБС, СӨБ, ЭМТ-ийн 358,833.4 мянган төгрөгийн хоол хүнсний материал, ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрийн 158,413.3 мянган төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан боловч оролцогч байхгүй тул өмнөх аж ахуй нэгжтэй үргэлжлүүлэн гэрээ байгуулж ажилласан байна. 2023 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 26 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10 арга хэмжээ хэрэгжээгүй, 16 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ шууд худалдан авалтаар хийгдэж үлдсэн 13 төсөл арга хэмжээ дээр тендер зарласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/75 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2023 оны нийт зарлага 2,630,548.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 39,458.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29,593.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд ИТХ-ын нэг удаагийн тэтгэмжийн зардлыг хэмнэсэн, хичээл үйлдвэрлэлийн зардал буюу хуралдааны зардлыг боломжит хэмжээгээр хэмнэсэн, ЗДТГ-ын засварын ажлын тендерийн хэмнэлтийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулаагүй, Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардлаас чухал шаардлагатай биш гэж үзсэн урсгал зардлыг гаргалгүй хэмнэсэн.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын шилэн дансны мэдээллийг шалгахад Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай

холбоотой 15 ажил мэдээлэхээс 12 ажил мэдээлж, 206,713.4 мянган төгрөгийн 3 ажил мэдээлээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж БНСБС-д төвлөрсөн 250.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэснийг залруулах, 116,125.1 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар газар худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнийг 94,6% хэрэгжүүлэн Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 01/271 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	927,653.6	3	877,560.3	94.6
<b>ДҮН</b>	<b>3</b>	<b>927,653.6</b>	<b>3</b>	<b>877,560.3</b>	<b>94.6</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын дараагийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2021-2022 онд хийгдсэн ажлыг хүлээж аваагүйтэй холбоотой авлага, өглөг үүссэн асуудалд анхаарал хандуулах мөн 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, хандив, зарцуулалттай холбоотой асуудлыг Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

### **5.1 Залруулсан алдаа**

Аудитаар нийт 83,202.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 83,202.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд Баянбулаг цэцэрлэгийн төлөвлөгөөг таталгүй 22,780.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, авлагын тодруулга тайланд 48,947.4 мянган төгрөг, өглөгийн тодруулга тайланд 11,473.8 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актгүй үлдэгдлээр тодруулга тайланд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 605,566.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, алдаа зөрчлийн давтан гаргахгүй байх 605,566.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт байхгүй болно.

### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага байхгүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Татварын болон татварын бус орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй

#### Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 70,504.9 мянган төгрөг, газрын төлбөр 20,919.5 мянган төгрөг, суутган-2 татвар 1,717.2 мянган төгрөг, галт зэвсгийн албан татвар 210.0 мянган төгрөг, ойн төлбөр 2,433.3 мянган төгрөг, түрээсийн төлбөр 250.2 мянган төгрөг, нэр зааж ангилагдаагүй орлого 205,055.9 мянган төгрөгөөр нийт 7 төрлийн орлого 301,090.9 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана. 24.3.Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана гэсэн заалт болон санхүүгийн

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангийн “толилуулга”, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, татварын орлогыг бааз суурийг нэмэгдүүлэх, орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар үр дүнд хүрсэн ажил зохион байгуулах

2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Төсөвт байгууллагуудын татварын өр, авлагын тодорхойлолтыг татварын цахим системээр 1,407.6 мянган төгрөгийн дутуу төлөлттэй, 96,354.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн нь ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын цахим системд алдаатай зөрүүтэй мэдээллийг засах талаар аймгийн Татварын хэлтэс хандан зөрчлийг арилгах

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гүйцэтгэлийг хянан үзэхэд 5 ажил төлөвлөснөөс 2 ажил хийгдээгүй, ажлын хэсгийн ажил хангалтгүй зохион байгуулагдсан байна. Энэ нь МУЗГ-ын 2011 оны 311 тоот тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.2-д “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна”, 3.3-д “Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын ажлын хэсэгт бүтэц нэгжээс хараат бус, тухай байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшсэн, ажлын туршлагатай албан хаагчаар улиралд нэгээс доошгүй удаа удирдлагын хурлаар хэлэлцүүлж, хамт олонд мэдээлж ажиллах

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны үйл ажиллагааг шалгахад Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой 15 ажил мэдээлэхээс 206,713.4 мянган төгрөгийн 3 ажил мэдээлэгдээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4

дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тогтоосон хугацаанд ойлгомжтой бүрэн мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	83,202.3			3	83,202.3						
Орон нутгийн хөгжлийн сан	1	2,757.0			1	2,757.0	1	2,757.0				
Хоршоо хөгжүүлэх сан	1	365,003.1			1	365,003.1	1	365,003.1				
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	4,792.9	1	4,792.9			1	4,792.9				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>455,755.3</b>	<b>1</b>	<b>4,792.9</b>	<b>5</b>	<b>450,962.4</b>	<b>3</b>	<b>372,552.9</b>	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Засаг дарга	3	398,852.6					3	398,852.6				
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	73,730.6	1	2,525.3			1	71,205.3				
Засаг даргын тамгын газар	9	1,067,205.9	1	11,337.1	1	26,006.6	7	1,029,862.2				
Орон нутгийн хөгжлийн сан	-	-						-				
Хоршоо хөгжүүлэх сан	1	7,000.0					1	7,000.0				
Эмийн эргэлтийн сан	-	-						-				
Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан	-	-						-				
Эко төв жаргалант ОНӨААТҮГ	-	-						-				
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>1,546,789.1</b>	<b>2</b>	<b>13,862.4</b>	<b>1</b>	<b>26,006.6</b>	<b>12</b>	<b>1,506,920.1</b>	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	206,713.4					1	206,713.4
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	71,205.3					1	71,205.3
Засаг даргын тамгын газар	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>71,205.3</b>					<b>2</b>	<b>71,205.3</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>71,205.3</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>71,205.3</b>

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
		санал дүгнэлт гаргах	Түвэрт хамрагдах	Аудит хийгээгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
1	2	3	4	5	6	7	8	9
Төсвийн шууд захирагч	2	1	1			1		
Орон нутгийн тусгай сан	4		4					
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1			1			
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>